



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Сүхбаатар сум  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Баасансүрэн  
Утас: 70362442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-21
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11-12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-22
4. Аудитын тайлан	22-27
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22-23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23-24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. Аудитын илрүүлэлт	25-29
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	29-30

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Т.БОЛДБААТАР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № СЭА-2025/001/НА-СТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 7 дугаар зүйлийн 7.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14.4.3, 20.2.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1, 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 4 дүгээр сард нэмэгдсэн цалингаас тооцож сумын ИТХ нь 2 албан хаагчид 114.7 мянган төгрөг, ЗДТГ нь 7 албан хаагчид 589.0 мянган төгрөг зэрэг нийт **703.7** мянган төгрөгийг илүү олгосон,
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр Рашаант 1 дүгээр багийн Засаг дарга Б.Отгонбаярт 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулалд 550.0 мянган төгрөгийг олгосон,
- Аймгийн Засаг даргын 2015 оны А/475 дугаар захирамжаар батлагдсан орон тоог хэтрүүлэн, сумын ЗДТГ-ын дарга болон Рашаант тосгоны захирагчийн тушаалаар 5 хүнийг албан тушаалд томилон ажиллуулж төсвөөс нийт **65,635.7** мянган төгрөгийн цалин, урамшуулал олгосон,
- Сумын ИТХ, ЗДТГ, Рашаант тосгоны Захирагчийн алба нь нийт **3,904.5** мянган төгрөгийг зориулалт бусаар буюу зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Сумын ЗДТГ нь санхүүгийн программын 270.0 мянган төгрөгийн өр төлбөрийг өмнөх оны санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан,
- Хууль бусаар бусдаас нийт 71,300.0 мянган төгрөгийн хандив төвлөрүүлж, зарцуулсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зургийг хадгалан үлдээх зорилгоор 4,879.6 мянган төгрөгийг зарцуулсан,
- Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын дүнгээр нийт мэдээлбэл зохих 513 мэдээллээс 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар тус бүр 20,000.0 мянган төгрөгийн, нийт 40,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомыг нэмэгдүүлэх, шинэчлэх”, “Бөхийн дэвжээ худалдан авах” төсөл, арга хэмжээг тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж бус “Ирээдүйд хөтөлсөн өргөө”, “Орхонтуулын хүчтэн” НҮТББ-уудтай шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн,
- Рашаант тосгоны Захирагчийн алба нь шууд худалдан авах босго үнээс давсан 48,000.0 мянган төгрөгийн нүүрсний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 124,089.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орхонтуул сумын ИТХ-ын “Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 103 дугаар тогтоолоор тайлант онд 863,362.4 мянган төгрөгийн татварын орлого, 30,136.2 мянган төгрөгийн татварын бус орлого, зэрэг нийт 893,498.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 904,245.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

## **Аудитын гол асуудал**

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 14-ийг нь бүрэн хэрэгжүүлсэн бол цахим тендерт санал ирүүлээгүй, хугацаа оройтож гэрээ байгуулсан, малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө тасарсан зэргээс шалтгаалж 9 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 1 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Орхонтуул сумын Засаг дарга нь тайлант онд 3 зорилт, 129 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 87.9 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,151,961.00	2,241,788.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	877,874.90	2,002,991.00
33	АВЛАГА	204,118.50	157,849.50
35	БАРАА МАТЕРИАЛ	69,967.60	80,947.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,848,225.90	9,622,010.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,848,225.90	9,622,010.30
39200	Биет хөрөнгө	8,842,413.90	9,121,152.70
39300	Биет бус хөрөнгө	5,812.00	500,857.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,000,186.90	11,863,798.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	50,717.90	28,716.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,717.90	28,716.60
41300	Өглөг	50,717.90	28,716.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,949,468.90	11,835,082.00
51	Засгийн газрын хувь оролцоо	9,949,468.90	11,835,082.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	462,549.00	520,089.00
51200	Хуримтлагдсан үр дүн	8,875,575.90	10,712,815.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	611,344.00	602,177.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,000,186.90	11,863,798.60

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,956,511.60	4,979,377.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	661,437.20	869,572.80
110	Орлогын албан татвар	270,652.60	559,179.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	311,172.90	609,665.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-40,520.30	-50,486.40
113	Хөрөнгийн албан татвар	216,590.70	222,869.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	174,193.90	87,523.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,757,618.50	915,246.20
120	Нийтлэг татварын бус орлого	6,757,618.50	915,246.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,537,455.90	3,194,558.30
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,792,290.60	2,536,936.50

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,792,290.60	2,536,936.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,785,455.60	2,508,824.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,637.40	1,001,538.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,955.50	124,272.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,777.10	590,864.90
2104	Хангамж, бараа материалын зардал	36,278.20	54,412.20
2105	Нормативт зардал	270	859
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,152.50	23,110.20
2107	Томилолт, зочны зардал	5,796.30	8,907.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	499,583.60	32,652.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	539,005.00	672,207.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,835.00	28,112.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,164,221.00	2,442,440.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	518,958.20	614,367.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,645,262.80	1,828,073.10

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,259,798.50	4,212,871.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	661,437.20	869,572.80
110	Орлогын албан татвар	270,652.60	559,179.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	311,172.90	609,665.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(40,520.30)	(50,486.40)
113	Хөрөнгийн албан татвар	216,590.70	222,869.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	174,193.90	87,523.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,721.90	8,484.00
1181	Газрын төлбөр	146,410.00	52,368.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	25,062.00	26,671.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,480.50	144,311.80
120	Нийтлэг татварын бус орлого	99,480.50	144,311.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,498,880.80	3,198,986.70
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,358,005.40	2,001,271.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,358,005.40	2,001,271.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,351,170.40	1,973,158.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	547,768.30	1,002,536.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,954.60	124,407.80

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,382.60	594,603.10
2104	Хангамж, бараа материалын зардал	30,444.10	57,076.60
2105	Нормативт зардал	270.00	1,060.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,152.50	27,092.60
2107	Томилолт, зочны зардал	5,796.30	8,907.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,222.90	31,117.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,179.10	126,357.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,835.00	28,112.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	901,793.00	2,211,600.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	680,744.90	1,086,484.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	680,744.90	1,086,484.20
2200	Дотоод эх үүсвэрээр	680,744.90	1,086,484.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(680,744.90)	(1,086,484.20)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(150,000.00)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	71,048.10	1,125,116.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	806,826.80	877,874.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	877,874.90	2,002,991.00

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,304,206.10	-	3,304,206.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,304,206.10	-	3,304,206.10
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	6,645,262.80	-	6,645,262.80
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,949,468.90	-	9,949,468.90
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,949,468.90	-	9,949,468.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,166.70	-	9,166.70
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,958,635.60	-	9,958,635.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(9,166.70)	-	(9,166.70)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	1,885,613.10	-	1,885,613.10
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,835,082.00	-	11,835,082.00

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,640,694.20</b>	<b>3,003,126.90</b>	<b>1,637,567.30</b>	<b>64.71</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,243,442.20</b>	<b>1,920,118.68</b>	<b>323,323.52</b>	<b>85.59</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,215,122.20</b>	<b>1,892,006.24</b>	<b>323,115.96</b>	<b>85.41</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,118,490.80	1,000,268.70	118,222.10	89.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,782.80	124,407.79	15,375.01	89.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	722,074.30	594,603.07	127,471.23	82.35
2104	Хангамж, бараа материалын зардал	55,009.10	5,747.82	49,261.28	94.07
2105	Норматив зардал	1,287.20	1,060.60	226.60	82.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,868.80	28,478.61	9,390.19	75.20
2107	Томилолт, зочны зардал	9,321.00	8,907.20	413.80	95.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,334.70	31,117.00	32,217.70	49.13
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	67,953.50	51,415.40	16,538.10	75.66
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,320.00</b>	<b>28,112.45</b>	<b>207.55</b>	<b>99.27</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,320.00	28,112.45	207.55	99.27
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,335,739.90</b>	<b>1,083,008.21</b>	<b>1,252,731.69</b>	<b>46.37</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	61,512.10	-	61,512.10	
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,640,694.20</b>	<b>3,912,503.11</b>	<b>728,191.09</b>	<b>84.31</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>4,590,194.20</b>	<b>3,857,212.89</b>	<b>732,981.31</b>	<b>84.03</b>
320001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,867,686.40	2,194,992.70	672,693.70	76.54
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,722,507.80	1,662,200.10	60,307.70	96.50
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>50,500.00</b>	<b>55,290.20</b>	<b>(4,790.20)</b>	<b>109.49</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,500.00	55,290.20	(4,790.20)	109.49

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,428.40</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,428.40</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,428.40</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,134.00
210104	Урамшуулал	1,134.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,664.40</b>
210401	Бичиг хэрэг	896.60
210402	Тээвэр шатахуун	1,767.80
2109	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>630.00</b>
210901	Бараа, үйлчилгээний бусад зардал	630.00
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,428.40</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,428.40
131103	ЗГНХ,ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	369.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,623.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,435.00

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч ( цаашид Орхонтуул сумын ТТЗ гэх ) нь тайлант оны үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Дээд шатны байгууллагын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, өөрийн сумын онцлогт тохирсон бодлогыг боловсруулах, төрийн үйлчилгээг шинэлэг хэлбэрээр хүртээмжтэй хүргэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- *Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,*
- *Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,*
- *Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,*
- *Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,*
- *Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,*
- *Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.*

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Тайлант онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас бие даасан дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсвийн гүйцэтгэлийн

тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Орхонтуул сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус сумын ТТЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,863,611.8 мянган төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	877,874.9	2,002,991.0	1,125,116.1
Авлага	204,118.5	157,849.5	(46,269.0)
Бараа материал	69,967.6	80,947.9	10,980.3
Үндсэн хөрөнгө	8,848,225.9	9,622,010.3	773,784.4

<b>Нийт хөрөнгө</b>	<b>10,000,186.9</b>	<b>11,863,798.7</b>	<b>1,863,611.8</b>
Өр төлбөр	50,718.0	28,716.7	(22,001.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,949,468.9	11,835,082.0	1,885,613.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>10,000,186.9</b>	<b>11,863,798.7</b>	<b>1,863,611.8</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,002,991.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,125,116.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	877,874.9	2,002,991.0	1,125,116.1
Төрийн сангийн харилцах	877,874.9	2,002,991.0	1,125,116.1
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
<b>Дүн</b>	<b>877,874.9</b>	<b>2,002,991.0</b>	<b>1,125,116.1</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 670,693.9 мянган төгрөг, ОНХС-ийн 1,244,925.3 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 58,937.0 мянган төгрөг, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн 28,434.8 мянган төгрөг тус тус тайлагнагдсан байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 157,849.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 46,269.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	578.7	-	(578.7)
Хувь хүмүүсээс авах авлага	3,366.8	3,366.8	-
Зээлийн авлага	198,477.2	154,482.7	(43,994.5)
Зээлийн хүүгийн авлага	1,695.8	-	(1,695.8)
<b>Дүн</b>	<b>204,118.5</b>	<b>157,849.5</b>	<b>(46,269.0)</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд хувь хүнээс авах 3,366.8 мянган төгрөг ( эзэн холбогдогч нь тодорхойгүй, 5-аас дээш жилийн насжилттай орон нутгийн ерөнхий орлогын 2,377.1 мянган төгрөг, сумын ЗДТГ-ын 989.9 мянган төгрөг) -ийн, ХХС-ийн зээлийн 154,482.7 мянган төгрөгийн авлагууд тайлагнагдсан байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 97.8 хувь буюу 154,482.7 мянган төгрөгийг ХХС-ийн авлага (8 иргэний 146,000.0 мянган төгрөгийн зээлийн, 8,482.7 мянган төгрөгийн зээлийн хүүгийн авлага) эзэлж байна.

Дээрхээс нийт 142,260.2 мянган төгрөгийн 5 зээлдэгчийн зээл, зээлийн хүү хуваарийн дагуу хэвийн төлөлтэй байгаа бол 3 зээлдэгчид олгосон нийт 11,278.1 мянган төгрөгийн зээл (2011 онд олгосон, зээлдэгч нь нас барсан, хамтран зээлдэгчгүй 2 иргэнд хамааралтай 3,913.7 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 2013 онд олгосон 1 зээлдэгчийн 7,364.4 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн) -ийн хугацаа хэтэрсэн байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 80,947.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,980.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	2,821.7	7,257.1	4,435.4
Бичиг хэргийн материал	2,540.2	3,265.2	725.0
Аж ахуйн материал	-	1,500.0	1,500.0
Бусад хангамжийн материал	64,605.7	68,925.6	4,319.9
<b>Дүн</b>	<b>69,967.6</b>	<b>80,947.9</b>	<b>10,980.3</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 10,980.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,098,162.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, аймгийн БОГ-аас 697.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан зэрэг нийт 1,098,859.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 100,045.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 987,833.6 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагад хүлээлгэж өгснөөс шалтгаалсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 9,622,010.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 773,784.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>8,842,413.8</b>	<b>9,121,152.6</b>	<b>278,738.8</b>

Барилга, байгууламж, орон сууц	1,382,715.6	1,406,578.5	23,862.9
Авто-тээврийн хэрэгсэл	225,920.0	437,568.4	211,648.4
Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,497.3	141,401.4	(12,095.9)
Тавилга, аж ахуйн эд хогшил	18,307.5	12,850.5	(5,457.0)
Зам гүүрийн байгууламж	433,384.7	446,164.4	12,779.7
Дуусаагүй барилга	6,352,480.2	6,352,480.2	-
Бусад үндсэн хөрөнгө	276,108.5	324,109.2	48,000.7
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>5,812.0</b>	<b>500,857.6</b>	<b>495,045.6</b>
Программ хангамж	1,000.0	300.0	(700.0)
Бусад биет бус хөрөнгө	4,812.0	500,557.6	495,745.6
<b>Дүн</b>	<b>8,848,225.9</b>	<b>9,622,010.3</b>	<b>773,784.4</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 773,784.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 3,476.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймгийн БОГ-аас 5,106.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, сумын ЗДТГ, Рашаант тосгоны Захирагчийн албаны эзэмшлийн газруудад үнэлгээ хийлгэж, нийт 495,745.6 мянган төгрөгийн газрыг биет бус хөрөнгөд бүртгэсэн, 262,647.3 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулснаас голлон шалтгаалсан байна.

Аймгийн ИТХ-ын хөрөнгөд бүртгэлтэй 10,000.0 мянган төгрөгийн дансны үнэтэй Тоёота Хариер маркийн автомашиныг ИТХТ-ийн 2019 оны 11 дүгээр тогтоолоор тус сумын ЗДТГ-т шилжүүлсэн боловч актаар хүлээн аваагүй, орлогод бүртгэж тайлагнаагүй байсан бөгөөд ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор хөрөнгийг актлах шийдвэр гарснаар уг автомашиныг сумын ЗДТГ орлогод бүртгэж, хасалт хийсэн байна.

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон нийт 467,163.8 мянган төгрөгийн өртөгтэй дараах хөрөнгийг орлогод авч, бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Сумын ОНХО-аар хэрэгжүүлсэн 62,575.0 мянган төгрөгийн өртөгтэй “ЗДТГ-ын конторын сантехник засварлах”, 47,591.8 мянган төгрөгийн өртөгтэй “ЗДТГ-ын байрны хэсэгчлэн засвар хийх”,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 79,557.0 мянган төгрөгийн өртөгтэй “Гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх”, 20,000.0 өртөгтэй “Гудамж, зам талбайг камержуулах”, 97,000.0 мянган төгрөгийн өртөгтэй “Малчид, иргэдэд нэг цонхны үйлчилгээ үзүүлэх дунд оврын автобус” 72,160.0 мянган төгрөг өртөгтэй “Баянцогтын 2-р багт ковш трактор”, 68,280.0 мянган төгрөгийн өртөгтэй “Рашаант тосгоны иргэдэд явуулын иргэний танхимын үйлчилгээ үзүүлэх автомашин”, 20,000.0 мянган төгрөгийн өртөгтэй “Бөхийн дэвжээ” гэх мэт.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 28,716.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 22,001.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	50,717.9	28,716.6	(22,001.3)
<b>Дүн</b>	<b>50,717.9</b>	<b>28,716.6</b>	<b>(22,001.3)</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн 28,434.7 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын данснаас байгууллагад төлөх 281.9 мянган төгрөг зэрэг нийт 28,716.6 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 11,835,082.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,885,613.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	462,549.0	520,089.0	57,540.0
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>8,875,575.9</b>	<b>10,712,815.6</b>	<b>1,837,239.7</b>
Өмнөх үеийн үр дүн	2,230,313.1	8,884,742.5	6,654,429.4
Тайлант үеийн үр дүн	6,645,262.8	1,828,073.1	(4,817,189.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	611,344.0	602,177.3	(9,166.7)
<b>Дүн</b>	<b>9,949,468.9</b>	<b>11,835,082.0</b>	<b>1,885,613.1</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,885,613.1 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Орхонтуул сумын ИТХ-ын “Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 103 дугаар тогтоолоор тайлант онд 863,362.4 мянган төгрөгийн татварын орлого, 30,136.2 мянган төгрөгийн татварын бус орлого, зэрэг нийт 893,498.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 904,245.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 1.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>863,362.4</b>	<b>869,572.8</b>	<b>6,210.4</b>	<b>100.7</b>
Цалин хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	248,713.1	402,549.0	153,835.9	161.8
Үйл ажиллагааны орлого	126,853.3	168,500.5	41,647.2	132.8
Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	37,039.2	28,776.2	(826.3)	77.7
Хөрөнгө борлуулсны орлого	6,790.5	9,840.0	3,049.5	145.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(50,486.4)	(50,486.4)	-	-
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	7,000.0	11,610.7	4,610.7	165.8
Бууны албан татвар	1,200.0	810.0	(390.0)	67.5
Малын тоо толгойн албан татвар	331,000.0	210,449.2	(120,550.8)	63.6
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	1,941.9	(1,058.1)	64.7
Хог хаягдлын хураамжийн орлого	5,000.0	6,542.1	1,542.1	130.8
Газрын төлбөр	133,146.7	52,368.7	(80,778.0)	39.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	14,106.0	26,671.0	12,565.0	189.1
<b>Татварын бус бусад орлого</b>	<b>30,136.2</b>	<b>34,672.6</b>	<b>4,536.4</b>	<b>115.0</b>
Нэр заагдаагүй бусад орлого	16,000.0	16,990.2	990.2	106.2
Хүү, торгуулийн орлого	14,136.2	17,682.4	3,546.2	125.1
<b>Нийт дүн</b>	<b>893,498.6</b>	<b>904,245.4</b>	<b>10,746.8</b>	<b>101.2</b>

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 153,835.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 41,647.2 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 3,049.5 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 4,610.7 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамжийн орлого 1,542.1 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 12,565.0 мянган төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 990.2 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 3,546.2 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүүгийн татварын орлого/ 826.3 мянган төгрөгөөр, бууны албан татвар 390.0 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 120,550.8 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 1,058.1 мянган төгрөгөөр, газрын төлбөр 80,778.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

#### **Давж биелсэн орлогууд:**

- **Цалин хөлс, түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого:** Цалин, хөлснөөс суутгасан ХХОАТ-ыг сумын орлогод төвлөрүүлсэнтэй холбоотой,
- **Үйл ажиллагааны орлого:** Малчдад олгосон ноос, ноолуурын урамшуулалд ХХОАТ ногдуулж, төвлөрүүлсэнтэй холбоотой,
- **Хөрөнгө борлуулсны орлого:** Иргэдийн хөрөнгийн борлуулалт нэмэгдсэнтэй холбоотой,
- **Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого:** Иргэдийн хөрөнгийн худалдан авалт нэмэгдсэнтэй холбоотой,

- **Хог хаягдлын хураамжийн орлого:** Айл өрх, аж ахуй нэгж, байгууллагаас хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлсэнтэй холбоотой,
- **Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого:** Иргэдийн хадлангийн талбайг нэмэгдүүлж олгосноор төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна.
- **Хүү, торгуулийн орлого:** Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### Тасарсан орлогууд:

- **Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүүгийн татварын орлого/:** Төрийн банкин дахь иргэдийн хадгаламжийн хэмжээ буурснаас шалтгаалсан,
- **Бууны болон малын тоо толгойн албан татвар:** Тус сумын татварын байцаагч нь жирэмсэн амаржсаны амралттай тул Баруунбүрэн сумын татварын байцаагч хавсран ажиллаж, орлогын бүрдүүлэлтэд хяналт тавиагүйгээс шалтгаалсан,
- **Улсын тэмдэгтийн хураамж болон газрын төлбөр:** Орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс шалтгаалсан,
- **Газрын төлбөр:** Цахим бүртгэл нэвтэрсэнтэй холбоотойгоор иргэдийн эзэмшил, өмчлөлийн газрын төлбөрийг иргэн бүрд ноогдуулсан боловч төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,491,361.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 82 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,053,834.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,367,574.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,649,810.5 мянган төгрөг, орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 103,400.0 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын урьд оны үлдэгдлээс санхүүжих 170,000.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 50,000.0 мянган төгрөг, ХХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 12,878.0 мянган төгрөг зэрэг нийт **4,407,996.9** мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 86 дугаар “Хоршоо хөгжүүлэх сангийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолоор тус сангийн зээл олголтыг 61,512.1 мянган төгрөг, хяналтын үйл ажиллагааны зардлыг 1,365.9 мянган төгрөг зэрэг нийт **62,878.0** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 103 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 160,335.8 мянган төгрөгөөр бууруулж, 893,498.6 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөг,

аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,527,909.8 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,722,507.8 мянган төгрөг, орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 263,400.0 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын урьд оны үлдэгдлээс санхүүжих 170,000.0 мянган төгрөг, ХХС-ийн 62,878.0 мянган төгрөг нийт **4,640,694.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Хоршоо хөгжүүлэх сангийн анх батлагдсан төсөвт тодотгол хийгээгүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 17 хөтөлбөрийн 39 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,640,694.2 мянган төгрөгийн төсөв батлагдснаас 2,243,442.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 2,335,739.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 61,512.1 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлого 904,245.4 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,527,909.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 500.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 1,662,220.1 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 45,690.2 мянган төгрөг зэрэг нийт 4,140,565.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

*Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:*

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	160,502.0	151,746.3	8,755.7	94.5
2	Засаг даргын Тамгын газар	1,179,041.8	994,057.8	184,984.0	84.3
3	Рашаант тосгоны Захирагчийн алба	387,672.3	382,561.6	5,110.7	98.7
4	Орон нутгийн хөгжлийн сан	2,223,507.8	978,582.6	1,244,925.2	43.7
5	Хоршоо хөгжүүлэх сан	62,878.0	1,365.9	61,512.1	2.1
6	Орхонтуул сумын ЕБС	217,700.1	183,186.4	34,513.7	84.1
7	Рашаант тосгоны ЕБС	187,541.3	135,067.3	52,474.0	72.0
8	Орхонтуул сумын Эрүүл мэндийн төв	60,517.9	43,325.9	14,192.0	76.5
9	Рашаант тосгоны Эрүүл мэндийн төв	47,610.0	36,357.6	11,252.4	76.3
10	Орхонтуул сумын Цэцэрлэг	43,996.4	32,844.8	11,151.6	74.6
11	Орхонтуул сумын Соёлын төв	35,486.2	33,593.2	1,893.0	94.6
12	Рашаант тосгоны Соёлын төв	39,240.4	33,178.6	6,061.8	84.5
<b>Нийт дүн</b>		<b>4,640,694.2</b>	<b>3,003,126.9</b>	<b>1,637,567.3</b>	<b>64.7</b>

*Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,003,126.9 мянган төгрөг буюу 64.7 хувьтай тайлагнагдсан нь урсгал зардлыг 323,323.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,252,731.7 мянган төгрөгөөр, ХХС-аас олгох зээлийг 61,512.1 мянган төгрөг (Тайлант онд шалгуур хангасан төсөл, арга хэмжээ ирээгүй тул зээл олгогдоогүй байна.) -өөр хэмнэснээс тус тус шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 118,222.0 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 15,375.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал СЭА-2025/001/НА-СТА-ТТЗ

127,471.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 3,261.3 мянган төгрөгөөр, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал 226.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 9,390.2 мянган төгрөгөөр, томилолтын зардал 413.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 32,217.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 16,538.1 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 207.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн 2 төсөл, арга хэмжээнд 112,232.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 110,166.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 2,065.3 мянган төгрөг (*Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, хяналт тавиулаагүйгээс захиалагчийн хяналтын зардлыг зарцуулаагүй байна.*) -ийг зарцуулаагүй байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 24 төсөл, арга хэмжээнд 2,223,507.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 978,582.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 1,244,925.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 9 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, 1 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэнээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 2,993.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,435.0 мянган төгрөг, зэрэг нийт 4,428.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 1,134.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 2,664.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 630.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих 22 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний нийт		Үүнээс:					
	Тоо	Дүн	Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	22	2,203,507.8	5	100,000.0	10	597,507.8	7	1,506,000.0

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхонтуул сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/143 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,792,290.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 26,884.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд тус төвлөрүүлэн захирагч нь харьяа байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар тайлант оны эцэст батлагдсан төсвийг 35.3 хувиар хэмнэсэн байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Автомашинуудад бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар авсан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй зэрэг төсвийн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зургийг хадгалан үлдээх зорилгоор “Монголын баялаг өв соёл” ХХК-д 4,879.6 мянган төгрөгийг ЗДНХ-өөс шилжүүлж, гэрээт ажлыг хүлээн аваагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	171	167	4	-
2	Засаг даргын Тамгын газар	171	164	7	-
3	Рашаант тосгоны Захирагчийн алба	171	158	13	-
	<b>Нийт дүн</b>	<b>513</b>	<b>489</b>	<b>24</b>	<b>-</b>

Тус сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын дүнгээр нийт мэдээлбэл зохих 513 мэдээллээс 489 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөх.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**1.** Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар 2-3 удаа зарлаж, нэг ч санал ирээгүй үндэслэлээр сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар тус бүр 20,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомыг нэмэгдүүлэх, шинэчлэх”, “Бөхийн дэвжээ худалдан авах” төсөл, арга хэмжээг тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж бус “Ирээдүйд хөтөлсөн өргөө”, “Орхонтуулын хүчтэн” НҮТББ-уудтай гэрээ шууд байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь “Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.”, 54 дүгээр зүйлийн 54.8 дахь “Захиалагч энэ хуульд зааснаар хүргүүлэх урилгыг тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгчид нэгэн зэрэг хүргүүлнэ.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж байх зөвлөмж өгөв.

**2.** Рашаант тосгоны Захирагчийн алба нь шууд худалдан авах босго үнээс давсан 48,000.0 мянган төгрөгийн нүүрсний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ийн 1 дэх “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нүүрсний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж байх зөвлөмж өгөв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 172 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн бол 1 залруулагдаагүй алдаа, 1 зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	4	22,425.2	4	22,425.2	100
Зөвлөмж	2	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>22,425.2</b>	<b>4</b>	<b>22,425.2</b>	<b>66.6</b>

Өмнөх аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам” -ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэл, нийцлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад залруулсан алдаа<sup>1</sup> гараагүй болно.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,  
СЭА-2025/001/НА-СТА-ТТЗ

Аудитаар нийт 266,453.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,253.7 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 265,200.1 мянган төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

## 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант оны 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 4 дүгээр сард нэмэгдсэн цалингаас тооцож сумын ИТХ нь 2 албан хаагчид 114.7 мянган төгрөг, ЗДТГ нь 6 албан хаагчид 589.0 мянган төгрөг зэрэг нийт **703.7** мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:” 20.2.5 дахь “ ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр Рашаант 1 дүгээр багийн Засаг дарга Б.Отгонбаярт 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулалд 550.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.3 дахь “ ... улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1. Аймгийн Засаг даргын 2015 оны А/475 дугаар захирамжаар батлагдсан орон тоог хэтрүүлэн, сумын ЗДТГ-ын дарга болон Рашаант тосгоны захирагчийн тушаалаар 5 хүнийг дараах албан тушаалд томилон ажиллуулж, төсвөөс нийт **65,635.7** мянган төгрөгийн цалин, урамшуулал олгосон байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь гаталгат онгоцны операторчноор Ж.Ганболдыг гэрээгээр ажиллуулж, үндсэн цалингийн сангаас 3,630.0 мянган төгрөг,
- Рашаант тосгоны Захирагчийн алба нь цахилгаан, сантехник, тохижилт үйлчилгээ хариуцсан ажилтан Ё.Батхуягт 18,129.2 мянган төгрөг, С.Дагвасүмбэрэлд 3,000.0 мянган төгрөг, галч-жижүүр Б.Өсөхбаярт 17,398.5 мянган төгрөг, ковш машины жолооч П.Отгонбатад 23,478.0 мянган төгрөг гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3

дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан орон тоо, цалингийн сангийн хүрээнд үйл ажиллагаа явуулах албан шаардлага хүргүүлэв.

**2.** Дараах байгууллагууд нь нийт **3,904.5** мянган төгрөгийг зориулалт бусаар буюу зардлын эдийн засгийн ангилал, арга хэмжээ хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1.2 дахь заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” -ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

#### **ЗДТГ:**

- Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн төсвөөс ЗДТГ-ын даргын цэргийн хээрийн хувцасны төлбөрт 618.3 мянган төгрөг, мэдээллийн технологийн үйлчилгээний төсвөөс сейф худалдан авахад 180.5 мянган төгрөг, тогтмол зардлаас автомашины аккумулятор худалдан авахад 341.0 мянган төгрөг,

#### **ТТЗ:**

- Засаг даргын нөөц хөрөнгөөс жил бүр давтагддаг, урьдчилан төлөвлөх боломжтой, сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардал болох тохижилтын ажил буюу нохой устгалд 1,100.0 мянган төгрөг,
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас суманд шинээр баригдах спорт цогцолборын газрын кадастрын зураг хийлгэсний төлбөрт 900.0 мянган төгрөг.

#### **Рашаант тосгоны Захирагчийн алба:**

- Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний зардлаас бохирын шугам хоолой худалдан авахад 600.0 мянган төгрөг.

#### **ИТХ:**

- Шуудан холбоо, интернэтийн зардлаас хуралдааны зардалд 164.7 мянган төгрөг гэх мэт.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийж байх албан шаардлага хүргүүлэв.

**3.** Сумын ЗДТГ нь санхүүгийн программын 270.0 мянган төгрөгийн өр төлбөрийг өмнөх оны санхүүгийн тайланд тусгалгүйгээр тайлант оны батлагдсан

төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухай оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.”, 14.4.3: бүх өр төлбөр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн тохиолдолд санхүүгийн тайланд тусгасны үндсэн дээр барагдуулж байх албан шаардлага хүргүүлэв.

4. ТТЗ буюу сумын Засаг дарга нь дараах зориулалтаар бусдаас нийт 71,300.0 мянган төгрөгийн хандив төвлөрүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.”, 25.2.1: “эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2: “бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3: “соёлын үйлчилгээ” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогоос малын өвс, тэжээлийн нөөц бэлтгэхээр зохицуулагдсан атал бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэх иргэдтэй гэрээ байгуулан “Сумын аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс тэжээлийн төлбөр” нэрийдлээр нийт 26,300.0 мянган төгрөгийн хандивыг БХНС барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан,
- Сумын цэцэрлэгийн 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд тус цэцэрлэгийн багшаар удирдуулан байгуулсан “Ирээдүйд хөтөлсөн өргөө” төрийн бус байгууллагын арилжааны банкин дахь дансаар баяр наадмын зардалд иргэд, аж ахуйн нэгжүүдээс 45,000.0 мянган төгрөгийн хандив төвлөрүүлж, зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нутгийн захиргааны үйл ажиллагаанд хандивын орлого төвлөрүүлэхгүй байх, БХНС барьцаа дансыг зориулалтын дагуу ашиглаж байх албан шаардлага хүргүүлэв.

5. Сумын ЗДТГ нь өмнөх аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу алдааг давтан гаргасан байна. Үүнд:

- УТХО-аар хэрэгжиж буй Орхон голын төмөр бетонон гүүрний санхүүжилтийг дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэж, бараа материалыг нэмэгдүүлж бус үндсэн хөрөнгийн дансанд орлого авсан,
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 9 нэр төрлийн 124,089.9 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална, 5.1.4: “үнэн зөв байх” , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 дахь “... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” , Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.4 дэх “Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэлх хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам” -ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ	1	73,300.0	-	-	2	73,300.0						
Сумын ИТХ	2	279.4	1	114.7	1	164.7						
Сумын ЗДТГ	5	129,718.7	1	589.0	4	129,129.7						
Захирагчийн алба	3	63,155.7	1	550.0	2	62,605.7						

Дүн	11	266,453.8	3	1,253.7	9	265,200.1				
-----	----	-----------	---	---------	---	-----------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	/мянган төгрөгөөр/										
	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>											
Шилэн дансны мэдээллийг ИТХ нь 4, ЗДТГ нь 7, Рашаант тосгоны Захирагчийн алба нь 13 зэрэг нийт 24 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-	-	-	-	-	-	1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>		
<b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>											
Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй.	2	40,000.0						2	40,000.0		
Нүүрсний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй.	1	48,000.0						1	48,000.0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>88,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>88,000.0</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>											
Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зургийг хадгалан үлдээх зорилгоор "Монголын баялаг өв соёл" ХХК-д ЗДНХ-өөс шилжүүлсэн.	1	4,879.6			1	4,879.6					
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>4,879.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>4,879.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>92,879.6</b>			<b>1</b>	<b>4,879.6</b>	<b>4</b>	<b>88,000.0</b>			